



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 1а/267

Номгон


Г Хяналт шинжилгээ хийх, шалган туслах Г  
дэд ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "в" 29.1.6-гийн "а", "л", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.8 дахь заалт, Монгол Улсын засгийн газрын 2021 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 21 дүгээр хуралдааны тэмдэглэл, Улсын онцгой комиссын даргын 2021 оны 03 дугаар сарын 31-ний 01 дүгээр тогтоол, Улсын онцгой комиссын даргын 2021 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 30 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар Монгол Улсын засгийн газар, Улсын онцгой комиссоос гаргасан шийдвэрүүдийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх, шалган туслах үүрэг бүхий дэд ажлын хэсгийг байгуулж, бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Хүн амын дархлаажуулах, халдварын хавьтлыг тогтоох, тандалт судалгааг эрчимжүүлэх, гэрээр эмчлэх эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх, уул уурхайн олборлолт, зам барилга, дэд бүтэц, хөдөө аж ахуйн газар тариалангийн чиглэлийн үйл ажиллагааны тасралтгүй байдлын бэлтгэл ажлыг хангах, халдварын тархалтыг зогсоож, дэглэм сахиулах чиглэлээр хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж, мэдээ мэдээллийг Тагнуулын ерөнхий газрын даргын 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн А/37 дугаар тушаалаар байгуулагдсан дэд ажлын хэсэгт тухай бүр хүргүүлж ажиллахыг (Р.Мэндбаяр)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Батсуурь)-д даалгасугай.




ДАРГА

Д.МӨНХСАЙХАН

521010671

Аймгийн Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын  
20-ны өдрийн А/267 дугаар захирамжийн  
хэвсрэлт.



### ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙХ, ШАЛГАН ТУСЛАХ ДЭД АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: Р.Мэндбаяр –Тагнуулын ерөнхий газрын Баянхонгор аймаг дахь хэлтсийн дарга, дэд хурандаа

Нарийн бичгийн дарга: З.Золжаргал -Тагнуулын ерөнхий газрын Баянхонгор аймгийн хэлтсийн ахлах ажилтан, хошууч

Гишүүд: Л.Намжилмаа -Мэргэжлийн хяналтын газрын Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч

Т.Ерэнбаяр -Баянхонгор аймаг дахь Цагдаагийн газрын Эрүүгийн тасгийн эрүүгийн ахлах мөрдөгч ахмад

Х.Цэнд-Очир -Гал түймэр унтраах, аврах 14 дүгээр ангийн захирагч

Д.Балжмаа -Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн төвийн дарга

Ц.Батцэнгэл -Зооноз өвчин судлалын төвийн мэргэжилтэн